

**МОНГОЛ, ХЯТАД ХЭЛНИЙ ХҮНИЙ БИЕ ЭРХТНИЙ НЭР БҮХИЙ
ХЭЛЦ ҮГИЙН ТУХАЙ**

“Ам” бүхий хэлц үгийн жишээн дээр

Л.Солонго*

Агуулгын товч: Монгол, хятад хэлэнд хүний биеийн эрхтний нэр бүхий хэлц үг олон бий, энэхүү өгүүлэлд “□ kǒu / 嘴 zuǐ” буюу “ам” бүхий хэлц үгсийг хоёр хэлний утгын хүрээнд зэрэгцүүлэн үзэх юм.

Зангилаа үг: монгол хэл, хятад хэл, хэлц үг, хүний биеийн эрхтний нэр бүхий хэлц үг

Удиртгал

Ойрын жилүүдэд Хятад Монгол хэл шинжээч, судлаач, эрдэмтэд зэрэгцүүлсэн судалгаа идэвхтэй хийж байна. Тэр дундаа хоёр орны зуу зуун жилийн түүх соёл, ард түмний өв уламжлал, зан заншлын төдийгүй сэтгэхүйн онцлог, аж төрөхүйн өвөрмөц шинжийг өөртөө хадгалсан, үгийн сангийн нэгж болох “хэлц үг”-ийг бүтэц, утга, сэтгэц болон танихуйн, соёл-орон судлал гээд бүхий л талаас зэрэгцүүлэн судлах нь чухал болоод байгаа билээ. Бид өгүүлэлдээ хятад, монгол хэлний “□ (kǒu)” – “ам” хэмээх үг эс адилтгасан буюу хүний бие эрхтнийг шууд заан нэрлэсэн утгаар хэлц үгийн бүтцэд орж ямар утга илэрхийлж байгааг Ц.Базаррагчаагийн 7200 орчим хэлц үгийг багтаасан “Хятад-Монгол хэлцийн толь” (2010), 学者宝力高编著辽宁民族出版社出版的约 22000 余条成语的“汉蒙成语大词典” (2010), Г.Аким “Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь” (1982), Монсудар хэвлэлийн газрын “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” (2011) зэрэг толь бичгээс түүвэрлэн авч үзсэн юм.

Монгол хэлний хүний бие эрхтний нэр бүхий хэлц үгийн судалгаа

Монгол хэлний хэлц үгийн талаар өдгөө Г.Аким, Ж.Төмөрцэрэн, М.Базаррагчаа, Д.Бадамдорж, Ж.Баянсан, Ж.Бат-Ирээдүй нарын судлаачид олон талаас нь судлан, ном сурах, гарын авлага, толь бичиг, эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэн

* МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхим

гаргасаар байна.

Ж.Бат-Ирээдүй “Монгол хэлний хэлц үг, хэллэгийг ойрын жилүүдэд улам эрчимтэй судалж байна. Харин судлаач нар энэхүү хэлц үгийг янз бүрээр нэрлэн бичсээр байгаа боловч сүүлийн үед хэлц үг гэдэг нэр томьёо харьцангуй тогтвортой шинжтэй болж байгаа ба нэг ойлголтын талаар хэтэрхий олон нэр томьёо хэрэглэх нь хэрэглэгч, суралцагсдыг төөрүүлэх магадлалтай учраас бид цаашид хэлц гэдэг нэг л нэр томьёон дээр тогтож хэрэглэмээр санагдана” [Бат-Ирээдүй 2010:2] гэжээ. Бид энэхүү саналтай санал нэг байгаа бөгөөд цаашид “хэлц үг” гэсэн нэр томьёог хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ. Хүний бие эрхтний нэр бүхий хэлц үгийг судлаачид хэрхэн судалж ирснийг, түүний дотор “ам”-тай холбогдох хэлц үгийг авч үзье.

“Ам” хэмээх үгийг “Монгол хэлний товч тайлбар толь” [Цэвэл 1966:36-37]-д доорх таван утгаар тайлбарласан байна. Үүнд:

1. Хүн амьтны уруулын завсарх сүв (том ам)
2. Хүн амьтны хошуу уруулын завсарх, багалзуур хүртэлх хөндий (ам цангах, аман дотроо үглэх)
3. шилжсэн. Амсар нүх (уутны ам, тогооны ам)
4. шилжсэн. Өндөр газрын хооронд голын дагуу байх газар (Түнхэлийн ам)
5. шилжсэн. Үг хэл (хэл ам гаргах, хэл ам хийх)

Чой.Лувсанжав “Өвөрмиц хэллэгийг морь адууны ба мал аж ахуйн, амьтны ба монголчуудын аж байдал, зан суртахууны, хээр талын ба тооны үгсийн, өнгө заасан ба бие эрхтэний холбогдолтой” [Лувсанжав 2006:41-52] гэж ангилан, “Хэл бүхэнд хүний бие эрхтэний нэр оролцсон өвөрмиц хэллэг олон байдаг. Монгол хэлний өвөрмиц хэллэгийг ажиглахад, ийм өвөрмөц хэллэгийн дотор: элэг, хөл, ам, хэл, нүүр, зүрх, толгой, чих, гар оролцсон нь бусдаас олон байна” [Лувсанжав 2006:53-56] гэжээ. Тэрбээр, ам-тай өвөрмиц хэллэг нэлээд олон буйн дотор ам нь заримдаа үг, хэл зэрэг үгээр сэлгэх нь олон буйг тэмдэглээд ам алда-/үг алда-/

Ам сайтай-/өгүүлэх нь сайхан утгатай/

Ам муутай-/өгүүлэх нь утга муухай/

Ам хуурай байх /гүй/-/үргэлж ярин бай-/

Ам булаалда-/нэг нэгнээсээ өрсөн хэлэлцэ-/

Ам бузарла-/үг хэлээд үргүй дэмий/

Ам гара-/за гэ- буюу тангарагла-/

Амаа тата-/үг өгүүлэхээ цөөлө-/

Амаа ура-/их чалчи-/

Ам хала-/үг олширон яриа даамжира-/

Ам гашуун-/үг чанга/

Олны ам хазгай-/олонд нэр муутай/

Ам гэдгээ хэл-тэй хоршин хэрэглэх нь,

Хэл ам сугала-/олон юм шалан асуух/

Хэл ам татла-/хэл ам хүрэ-магтаалаас гай ирэ-/

Хэл ам чангаа-/хэл ам татла-/ зэрэг жишээ гаргасан байна.

М.Базаррагчаа “Монгол хэлний тогтвортой хэлц нэгжийг хүн, амьтан, ургамал, хүний бүтээсэн зүйл, адгуусны бүтээсэн зүйл, гариг ертөнц, сэтгэхүй, мэдрэхүй, хий үзэгдлийн холбогдолтой гэж зүйлчлэн хувааж болно” гэж 10 хуваагаад “хүн” гэсэн ангилалд “**хошуу** цорвой-, таван хялгас, арван хуруу тэгш, нуруугүй (хүн), **нүд** алд-, **аманд** ч үгүй, **хамарт** ч үгүй, улаан **хөлтийг** урдуураа гаргахгүй” [Базаррагчаа 1999:31] гэсэн жишээ авсан байна.

Д.Бадамдорж [2001:72] “Монгол хэлний өвөрмөц хэлцийг 1. тэнгэр мандал үүдэлт, 2. шим ертөнц үүдэлт, 3. сав ертөнц үүдэлт, 4. хөдөлгөөн үүдэлт, 5. хийсвэрлэл үүдэлт хэмээн утгын их орноор нь ерөнхийлөн утгазүйн ангилал хийн, уг сурвалжаараа хүнтэй холбоотой цөм утгат үгээр бүтэж, улмаар хүний зан чанар, ажил үйлс, мөс чанар зэргийг илтгэх утга санаатай өвөрмөц хэлц бүтсэн байна. Өөрөөр хэлбэл: **Хүн төвтэй** өвөрмөц хэлц бол хүний эд эрхтэнтэй холбоотой үгээс үүсээд, гол төлөв хүний хэрэг явдлыг илэрхийлсэн утгатай болжээ. Хүний л гэхэд, үснээс эхлээд, хөлийн ул хүртэлх бараг бүх эрхтэн, эд эсийн нэр оролцсон өвөрмөц хэлц байна” гээд, уг тус бүрт цөм утга харгалзах өвөрмөц хэлцээс жишээ гаргасан байна. Бидний судалгааны хүрээнд “ам/хэл”-тай холбогдох нь: чалчаа, яншаа утгыг илэрхийлсэн: ам задгай, задгай амтай, ам мэдэн ярих, ам хуурайгүй байх, ам халах, амаа хамхихгүй, ам хэлээ урчих шахах, амаа чихэндээ хүртэл цуурах; гэнэн, гэнэдэх утгыг илэрхийлсэн: ам алдах; хэрүүлч утгыг илэрхийлсэн: ам мухуйх, хэл амаа билүүдэх, ам шүдээ билүүдэх; сониучирхах утгыг илэрхийлсэн: аманд орчих шахах; ам бузарлах, амны гарз /хэлсний гарз болох/, ам булаалдах /өрсөн ярих/, ам гарах /бардамнах/, ам өгөх /амлах/, ам таглах, амаа таглуулах /хэлэх үггүй болгох/, ам сайн /олны сайн ярих нь/, ам муу /муу хэлэгдэх/, ам хатуу /хатуу үгийг шууд хэлэх/, амны хишиг /аз, заяа, буян/, амны зугаа болох /байнга яригдах/, ам ангайх /гайхах/, хэл ам гаргах /янз янзын яриа гарах/, хэл ам татлах /хэрүүл маргаан хийх/ гэх мэт.

Ж.Бат-Ирээдүй хэлц нэгжийг хэлзүйн талаас бичсэн өгүүлэлдээ, “Хэлц нэгжийг дотор нь нэр ба үйлийн дэвсгэрээр ерөнхийд нь хэлц бүтээвэр, хэлц үг, хэлц үгүүлбэр гэж гурав хувааж болох юм. Хэлц үгээ дотор нь нэр хэлц, үйл хэлц (үйл хэлцээ мөн дан үйл үгийн, холбоо үгийн гэж хувааж үзсэн), зүйрлэх хэлц, давтах хэлц (зүйрлэх болон давтсан хэлц нь хэлц үгийн айд хамаарах боловч биеэ даасан хэлцийн утга илэрхийлнэ гэж үзсэн, жишээ нь: **амаа** үдүүлсэн юм шиг $\approx$ дуугүй), хоршоо хэлц (**аманд** ч үгүй, **хамарт** ч үгүй) гэж хэд хувааж болно [Бат-Ирээдүй 2010:7-8]. Бид хүний биеийн эрхтний нэр бүхий хэлц үгийг ерөнхий бүрэлдүүлбэрээр нь нэр хэлц, үйл хэлц хэмээн хувааж болно гэж үзэж байна.

Хүний эд эрхтний нэр заасан үгс ихэндээ тухайн хэлний уугал үгс байдаг нь тодорхой юм. Монгол хэлний хэлц үгийн бүтцэд орсон хүний эд эрхтний нэрийг ажиглахад алга, ам, араа /шүд/, арьс, бие, борви, бөгс, бөөр, гар, гүзээ, гуя, гэдэс, дал, зовхи, зулай, зүрх, магнай, мах, мөр, нармай, нүд, нүүр, өвдөг, өвчүү, өлмий, өр, суга, тархи, толгой, ул, уушги, үнхэлцэг, үс, хавирга, хамар, хонго, хоолой, хошуу, хөл,

хумс, хуруу, хүзүү, хэл, царай, цөс, цээж, чих, шил, шөрмөс, шүд, элэг, эрүү, яс зэрэг 52 үгс байна. “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” (2011)-д “ам”-тай холбогдол бүхий нийт 192 хэлц үг байгаагийн дийлэнх нь буюу 136 нь үйл хэлц үг (ам гарздах, ам муруйх, ам өрсөлдөх, амаа таглуулах, амаараа шороо үмхэх, амыг нь ангайлгах гэх мэт), үлдсэн хэсэг нь холбоо нэр хэлц (амны гарз, амны хишиг, аман хүзүү, алтан амтай), тэмдэг нэрийн зүйлээс бүтсэн хэлц (ам задгай, ам хатуу, ам түргэн, ам завгүй, сул амтай гэх мэт) байна.

Хятад хэлний хүний бие эрхтний нэр бүхий хэлц үгийн судалгаа

Хятадын хэл шинжээч, судлаачид хэлц үгийн талаар өөр өөрийн зорилгоор, өөр өөр талаас судалж томъёолж байгаа боловч “成语” (chīngyǔ) буюу хэлц үг нь “бүтцийн хувьд маш тогтвортой, утгын нэгдмэл шинжтэй, нэг үгийг нөгөө үгээр солин хэлэхэд утга алдагддаг төдийгүй ихэвчлэн дөрвөн ханз үсгээс бүтсэн, тогтвортой нийлц юм” гэсэн тодорхойлолт нэлээд түгээмэл байна. Зарим судлаачид “хэлц үгийн гарал үүсэл заавал тодорхой байх ёстой, өөрөөр хэлбэл, аливаа нэг үлгэр домог, түүхэн үйл явдлаас үүдэлтэй байх шинжтэй. Хэлц үг бол хэвшмэл хэллэгийн нэг төрөл юм гээд зүйр үг, цэцэн үг, мэргэн үг, онч үг зэргийг хамтатган авч үзсэн [孙维张 1989:3] нь ч бий.

Бүтцийн хувьд хоёр буюу түүнээс дээш ханз үсгээс бүтэх хэлц үг байгаа хэдий ч, хятад хэлний нийт хэлц үгийн 96 орчим хувийг дөрвөн ханз үсэгтэй хэлц үг (四字格成语) эзэлж байна. Гэвч дөрвөн ханз үсэгтэй харьцангуй тогтвортой нийлэмж бүрийг хэлц үг гэж үзэх нь эндүүрэл бөгөөд нэгдүгээрт, хэлц үгийн дээр дурдсан онцлог шинж буй эсэхийг харах, хоёрдугаарт, мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо эсэхийг харах хэрэгтэй. Жишээ нь: 与众不同 –бусадтай адилгүй, 众所周知 –бүгд мэддэгээр бол, 马马虎虎 –тодорхой бус байх, 喜怒哀乐 –баяр баясгалан уйтгар гуниг, 电磁辐射 цахилгаан соронзон цацраг гэх мэт.

Судлаач 冯凌宇 [2008:11] хүний эрхтний нэр заасан үгсийг толгойн хэсгийн, тулгуур эрхтний, дөрвөн мөчийн, дотор эрхтний гэсэн дөрвөн гол бүлэгт хуваан үзэж, түүнд харгалзах дэд бүлгийн үгсийг харгалзуулан гаргажээ. Үүнд:

Толгойн хэсгийн бүлэг (头部语义场): толгой, нүүр, чих, нүд, хамар, ам, шүд, хэл, хоолой

Тулгуур эрхтний бүлэг (躯体语义场): хүзүү, мөр, цээж, гэдэс (гэдэсний хэсэг), нуруу, борви

Дөрвөн мөчийн бүлэг (四肢语义场): гар, шуу, суга, хөл, өвдөг, хөл, тавхай

Дотор эрхтний бүлэг (脏腑语义场): зүрх, элэг, бөөр, уушги, ходоод, дэлүү, цөс, давсаг, гэдэс зэргийг оруулан, эдгээр үгс хэрэглээний давтамж ихтэй, хэлц үгийн бүтцэд орж зүйрлэл утга илэрхийлэх нь элбэг гэжээ.

Мөн хүний биеийн эд эрхтний нэрийг явцуу болон өргөн хүрээнд авч судалдаг. Явцуу гэдэг нь 头 tóu-толгой, 手 shǒu-гар, 足/脚 zú/jiǎo-хөл, 眼睛 (目) yǎnjīng (мш)-нүд, 眉毛 mímao-хөмсөг зэрэг зөвхөн хүний биеийн эрхтний нэрээс бүтсэн

үгсийг хамруулж үздэг бол, өргөн хүрээнд дараах 4 бүтцээр авч үзнэ: 1. зөвхөн хүний эрхтний нэр заасан бүтээврээс үүсэн шууд утга нь өөрчлөгдөхгүй үгс 头 *tu*-толгой, 牙齿 *ubchī*-шүд, 眼睛 *yǎnjīng*-нүд гэх мэт; 2. хүний эрхтэн заасан бүтээвэр болон хүний эрхтний бус бүтээврээс үүсэн хүний биеийн эрхтэн заах үгс 大腿 *datuī*-гуя, 眼珠 *yǎnzhū*-нүдний болор, 鼻子 *bnzī*-хамар гэх мэт; 3. хүний биеийн эрхтэн заасан бүтээврээс үүссэн боловч өөр утга илэрхийлэх үгс 心胸 *xīnxiōng*- зориг, 眉目 *mīimù*-эмх цэгц гэх мэт; 4. хүний эрхтэн заасан бүтээвэр болон хүний эрхтний бус бүтээврээс үүсэн өөр утга илэрхийлэх үгс 伤心 *shāngxīn*-сэтгэл өвдөх, 插手 *chāshǒu*-гар дүрэх гэх мэт.

«现代汉语词典» буюу “Хятад хэлний толь бичиг” [2005:783]-т “口” (*kǒu*) “ам” хэмээх үгийг 1. Хүн амьтны хоол идэх, дуу авиа гаргах эрхтэн, мөн “嘴” (*zuǐ*) гэж хэлнэ; 2. Амт; 3. Ам бүл; 4. Савны гадагшлуулах хэсэг, амсар; 5. Нэвтрэх хэсэг; 6. Боомт; 7. Хувцасны ангархай цоорхой; 8. Адил болон ойролцоо үйл ажиллагаа явуулах байгууллагын салбарын нэр; 9. Хутга, сэлэм, хайч зэргийн ир; 10. Морь, илжиг, луус зэргийн нас; 11. Хүний тоолох нэгж; 12. Коу овог гэсэн 12 утгаар тайлбарласан байдаг.

Хятад хэлнээ хүний биеийн эрхтний нэр бүхий хэлц үг маш элбэг бөгөөд хүний сайн муу үйл, ёс суртахуун, залхуу хойрго зан, ажилч хичээнгүй байдал зэрэг хүнтэй холбоотой олон утгыг илэрхийлнэ. Хятад хэлний “口” (*kǒu*) буюу “ам” бүхий хэлц үг нэлээд бий. Түүн дундаа хэлзүйн бүтцийн хувьд 动宾式成语 буюу үйл үг+тусагдахууны бүтэцтэй хэлц үг зонхилж байна. Жишээ нь:

1. 口### буюу эхний үсгийн байрлалд орсон:

口不应心 ам ажил нь зөрөх

口出不逊 амны билиггүй

口蜜腹剑 ам нь бал аюулхай нь жад

口尚乳臭 амных нь салиа арилаагүй

口是心非 аман дээрээ ачтай ажил дээрээ бачтай, хэлэх хийх нь өөр

口中雌黄 тохь томоогүй хөнгөмсөг яриатай

2. #口## буюу хоёр дахь үсгийн байрлалд орсон:

冲口而出 амандаа орсноо ярих

顿口无言 ам нээнгүүд ээрч муурах

佛口蛇心 ам нь бурхан сэтгэл нь буг

缄口结舌 уруулаа үдүүлсэн юм шиг, таг дуугүй

交口称赞 ам амандаа магтацгаах

绝口不提 амаа хамхих

脱口而出 ам алдах

一口咬定 тас хэлэх

守口如瓶 амаа таг хамхих, ам чанга

笨嘴笨腮 чихэнд цэцэг ургатал ярьж чаддаггүй, дүлэгнэх

轻嘴薄舌 хөнгөн хуумгай яриа, бодлогогүй яриа

调嘴弄舌 ам худалдах

3. ##口# буюу гурав дахь үсгийн байрлалд орсон:

祸从口出 амнаасаа болж аюулд унах

目瞪口呆 амаа ангайн гайхах, мэл гайхах

心直口快 бодсон санаснаа шууд хэлэх, ам түргэн

4. ###口 буюу дөрөв дэх үсгийн байрлалд орсон:

锦心绣口 уран сэтгэж сайхан хэлэх

朗朗上口 ус цас шиг урсгах

良药苦口 сайн эм уухад гашуун ч өвчин намдаах

骂不绝口 ам хамхихгүй хараах

三缄其口 амаа хичээх гэх мэт.

“Хүмүүсийн өдөр тутмын амьдралд хүний биеийн эрхтний нэр заасан үгс хүний дотоод сэтгэлийн хөдөлгөөн, гадаад илрэлтэй шууд холбоотой байдаг. “口 (kǒu)” буюу “ам” бүхий хэлц үгэнд ч энэ нь илэрхий туссан байна, жишээлбэл, 心服口服 аман дээрээ төдийгүй сэтгэл дотроо ч бишрэх, 口是心非 хэлэх хийх нь өөр, аман дээрээ за ар хойноо түй, 目瞪口呆 үнэхээр их гайхаж байх нүүрний илрэл буюу мэл гайхах, 张口结舌 ам байвч үг ярихгүй байх илрэл буюу дув дуугүй байх гэх мэт” гэж судлаач 王国娟 [2011:118] жишээлэн бичсэн байна. Бидний түүвэрлэн авч үзсэнээр 宝力高“汉蒙成语大词典”(2010)-д “口 (kǒu)”-д холбогдох 260 орчим хэлц үг нь хүний муу үйлийг зэмлэн, сурган шүүмжлэх, ухааруулах ойлгуулах хийгээд хүний сайн сайхан үйлийг магтан сайшаах, урамшуулах утга, мөн уурлах, баярлах, туних, хөөрөх зэрэг сэтгэл хөдлөлийн нарийн ялгааг илэрхийлж байна.

Дүгнэлт

Монгол, хятад хэлний хүний биеийн эрхтний нэр “ам” “口 (kǒu)” хэмээх үг бүхий хэлц үг хүмүүсийн өдөр тутмын амьдралд идэвхтэй хэрэглэгдэх ба хэлзүйн бүтцийн хувьд монгол хэлэнд үйл хэлц, хятад хэлэнд үйл үг+тусагдахууны бүтэц (动宾式) бүхий хэлц үг зонхилж, утга шилжихдээ хүний ажил үйл, мөс чанар, зан суртахуунтай холбоотой зүйрлэсэн утга илэрхийлж байна.

НОМЗҮЙ

Монгол хэлээр:

1. Бадамдорж Д (2001), *Монгол хэлний утга судлал*, УБ, МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
2. Базаррагчаа М (1999), *Монгол хэл-VIII*, УБ, Монгол Улсын БСШУ-ны Яам.
3. Бат-Ирээдүй Ж (2010), *Монгол хэлний хэлц нэгжийн тогтолцооны тухай асуудалд*, Токиогийн Гадаад Хэлний Их Сургуулийн эрдэм шинжилгээний бичиг, №80, 2-р тал
4. Лувсанжав.Чой (2006), *Монгол хэлний өвөрмөц хэллэг*, Улаанбаатар, Хэл Иргэншлийн дээд сургууль.

5. Монгол хэлний овормоц хэлцийн толь (2011), Улаанбаатар, Монсудар хэвлэлийн газар.

6. Цэвэл Я (1966), Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх газар.

Хятад хэлээр:

1. 宝力高 (2010) 《汉蒙成语大词典》，辽宁民族出版社。
2. 冯凌宇 (2008) 《汉语人体词汇研究》，中国广播电视出版社。
3. 孙维张 (1989) 《汉语熟语学》，吉林教育出版社。
4. 王国娟 (2011) 《从认知角度看汉语“口”的隐喻用法》，青海师范大学学报，第 33 卷，第 1 期，第 118 页。
5. 中国社会科学院语言研究所 (2005) 《现代汉语词典》，第五版，商务印书馆。

SUMMARY

A wide range of Mongolian and Chinese language sayings incorporating the words for the human mouth (Mon. “*am*”, Chin. “口[kǒu]”) are used in everyday practice. In terms of their syntactic structure, Mongolian sayings are typically verbal whereas Chinese sayings typically involve a verb+object (动宾式); in terms of content they express meanings related to human activities, core qualities, and behaviour.